



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 18 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 18 дугаар хуралдаан 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр зохион болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 18 дугаар хуралдаанаар /2025-08-28/ Радио, телевизийн хөтөлбөрт 2024 оны жилийн эцсийн дүнгээр хэрэгжүүлсэн арга хэмжээ болон 2025 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн мониторингийн нэгдсэн дүн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга; ЦХИХХЯ-наас ирүүлсэн "Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 2G болон 3G технологид суурилсан үйлчилгээг зогсооход баримтлах чиглэл"-ийн төсөлд ХХЗХ-ноос хүргүүлэх саналын төслийн тухай танилцуулга; Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 150 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); "ХХЗХ-ны 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан" танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 7 (Тогтоол №185-191, 2025-08-28) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 18 дугаар хуралдаанаар Радио, телевизийн хөтөлбөрт 2024 оны жилийн эцсийн дүнгээр хэрэгжүүлсэн арга хэмжээ болон 2025 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн мониторингийн нэгдсэн дүн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулгыг авч хэлэлцээд, холбогдох ӨНЗГ-ын Э.Золбаяр дарга, холбогдох хариуцсан хэлтэс хамтран 2026 оны төсөв төлөвлөгөөг хэлэлцэн батлахаас өмнө Максима ХХК-тай газар дээр нь очиж үзэх, уулзалт хийх эргэж төсөв, төлөвлөгөө хэлэлцэх үеэр Хорооны дарга гишүүдэд мэдээлэхийг хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгов.

Түүнчлэн тус хуралдаанд ЦХИХХЯ-наас ирүүлсэн "Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 2G болон 3G технологид суурилсан үйлчилгээг зогсооход баримтлах чиглэл"-ийн төсөлд ХХЗХ-ноос хүргүүлэх саналын төслийн тухай танилцуулгыг боловсруулан холбогдох газар, ажлын хэсгээс хийв. Энэхүү асуудлыг хэлэлцээд, нэмэлт мэдээлэл, судалгааг гишүүдэд гаргаж өгөх, нэр бүхий гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу энэ асуудлыг яамны ТНБД, холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулах, баримт бичгийн төсөлд өөрчлөлт орсон болон яамны байр суурь хэвээрээ байгаа эсэх, яамны удирдлагатай зөвлөлдөж тодруулсны дараа асуудлыг Хорооны 2025 оны 10 сард багтаан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж Ажлын хэсэгт чиглэл өгөхөөр тогтов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаан /2025-07-08/-аар 2025 оны 150 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” (Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт) тогтоолыг баталсан юм. ХХЗХ-ноос энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/187 тоот тушаалаар үнэлгээний ажлын хэсэг байгуулагдаж, **ХХЗХ-2025 /ОНДД-СШ-01/** тоот “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс 60 хоногийн хугацаатай зарлан байгууллагын үндсэн цахим хуудасны мэдээ, мэдээлэл хэсэгт 2025 оны 07-р сарын 9-ны өдөр сонгон шалгаруулалтын урилга нийтлэгдсэн (<https://crc.gov.mn/posts/songon-salgaruulaltyn-urilga>) болно. Үнэлгээний ажлын хэсгээс сонгон шалгаруулалтыг зарлаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу материалыг хүлээн авч үнэлгээг хийж гүйцэтгэжээ.

Тус хуралдаанаар Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооноос 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт ХХЗХ-2025/ОНДД-СШ-01”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 185 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтаар, Тус хорооноос зарласан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт ХХЗХ-2025/ОНДД-СШ-01”-д Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ыг шалгарсанд тооцсугай; 2 дугаар заалтаар, Сонгон шалгаруулалтад шалгарсан Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т 21 аймгийн төвийн нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах радио станцад 76.1 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 2030 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; 3 дугаар заалтаар, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; 4 дүгээр заалтаар, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 18 дугаар хуралдаанаар “ХХЗХ-ны 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан”-гийн танилцуулгыг сонсож, Хорооны хуралдаанд 2026 төсөв, бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулах, хэлэлцүүлэхдээ хорооны гишүүдээс гарсан санал, зөвлөмж дагуу 2025 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төсөв зардлын задаргаа, хүрсэн үр дүнг ажил бүрээр тайлагнах; 2026 онд томоохон бүтээн байгуулалтын ажил арга хэмжээг үндэслэл, тооцоо судалгааны хамт тухайлбал, Орбит станц дах хяналтын төвийн шинэ барилгын хөрөнгө оруулалт, түүний ТЭЗҮ, БНХАУ-ын зээлийн

Баталгаажуулалтын төсөлтэй холбоотой барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалт, өөрийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтын төсөв зэргийг тусган хэрэгжүүлэх саналын хамт хорооны хуралдаанаар нэгтгэн хэлэлцүүлэх удирдамж, чиглэлийг хуралдааны энэхүү тэмдэглэлээр үүрэг болгож, Ажлын алба, бүх газруудад тус тус даалгав.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 18 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 6 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 6 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 186 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Одод телеком системс ХХК: Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 187 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Кастерлий рөүд ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –БНХАУ/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 188 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Хаан Алтай Ховд ХХК, 13400042 тоот : Ховд аймгийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 189 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Блю инфинити ХХК, 11300013 тоот: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 190 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 191 тоот тогтоолыг баталж, тогтоолын

хавсралтаар 1 хуулийн этгээдийн (Гаалийн ерөнхий газар ТБАГ) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунган тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-09-10